

Усыг бүс нутагт хуваарилан шилжүүлэх боломж, шаардлага

Э.Пүрэв-Эрдэнэ, С.Чинзориг

ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Усны нөөц, ус ашиглалтын салбар

Далай тэнгисээс алслагдсан, эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд усны нөөц жигд биш тархжээ. Нутгийн хойд хэсэг Хангай, Хэнтий, Хөвсгөлийн нутгаар гадаргын усны нөөц харьцангуй ихтэй боловч Хээр, говь, цөлийн бүсээр гадаргын усны нөөц нэн бага бөгөөд газрын доорх усны орд толбо байдлаар байна. Гэвч Монгол оронд эрчимтэй хөгжиж буй эдийн засгийн гол салбар болох уул уурхай, цаашилбал аж үйлдвэрийн цогцолборууд өмнөд говийн бүсэд төвлөрөх хандлагатай байна. Өмнөд говийн бүсэд одоо үйл ажиллагаа явуулж буй том, жижиг уул уурхайнууд одоогоор газрын доорх усыг ашиглаж байна. Гэвч тус бүс нутгийн газрын доорх усны нөөц нь тэжээмж нэн бага, хэдэн мянган жилийн настай “эртний” дарагдмал ус байдаг учраас экосистемийн хувьд говийн бүсэд байгаа томоохон уурхай, аж үйлдвэрийн төвийг усаар хангах боломж бага байна. 20000-45000 жилийн настай эртний, дарагдмал усаа соруулан ашиглах нь сайн зүйл биш. Харин өмнөд говийн бүс нутгийн газрын доорх усыг Монголын соёлыг өдий хүртэл тээж яваа манай орны эдийн засгийн суурь салбар болсон бэлчээрийн мал аж ахуй, аймгийн төв, шинэ, хуучин суурин газар, мөн зэрлэг ан амьтдыг усаар хангахад нэн тохиромжтой юм. Өөрөөр хэлбэл бага гүний ганцаарчилсан худгийн системээр хэрэглэгчдийг хангах боломж бий.

Өмнөд говийн бүс нутагт өсөн нэмэгдэж буй уур уурхай, аж үйлдвэрийн салбарын усны хэрэгцээ цаашид улам их нэмэгдэх хандлагатай байна. Манай орны хувьд жигд бүс тархсан усны нөөцийг зөв менежментийг хэрэгжүүлж усны нөөц харьцангуй их бүс нутгийн гадаргын усыг Говь, Хээрийн бүс нутгийн эдгээр ус ашиглагч руу усны алдагдал багатай шилжүүлэн ашиглуулах бүрэн боломж байгаа. Гадаргын усыг алсын зайд шилжүүлнэ гэдэг нь голын усыг




Эх үүсвэр: <https://gobimedia.mn/index.php?newsid=1053>

бүхэлд нь, голдирлын өөрчлөн шилжүүлнэ гэсэн үг биш юм. Хаврын шар усны үерийн ус, зуны хур борооны үерийн усыг гидротехникийн арга хэмжээг ашиглан цуглуулан хуримтлуулж тухайн голын экосистемд нөлөө үзүүлэхгүйгээр тодорхой хэсгийг авч шилжүүлэх явдал юм.

Дэлхий хөгжингүй томоохон улсад энэ аргаар хуурай бус нутгаа усаар хангаж байгаа олон жишээ бий. Хятад улс өмнөд хэсэгт орших Хөх мөрнөөс ус татаж хуурай гандуу бүс нутгаа усаар хангах төслийг хэрэгжүүлж байна. Австрали улс алслагдсан хуурай бус нутаг руу 600 км урт яндан хоолойгоор ус татан ашиглаж байна. Саудын Араб, Ливи улсууд мөн усыг алсын зайд шилжүүлэн ашиглах төслүүдийг хэрэгжүүлж байгаа олон жишээ бий. Манай орны хувьд ч гадаргын усыг 50 гаруй км урт хоолойгоор Тайширын Гэгээ нуураас Алтай хот руу шилжүүлэн хэрэглэж байна.

Манай орны ус хангамжийн гол эх үүсвэр газрын доорх ус бөгөөд газрын доорх усыг татан шилжүүлэн ашиглаж буй арвин туршлагатай. 1960 оноос Туул голын хөндийгөөс 80 км ус хангамжийн хоолой, 1978 онд Сэлэнгэ-Эрдэнэтийн 64 км 4 шатлалт насос станцтай шугам, Увс аймгийн Хархираа голын усыг 46 км яндан хоолойгоор татаж 2000 га усалгааны бороожуулах машиныг автоматаар ажиллуулах хоолойн систем, Дундговийн төвийн ус хангамжийн шийдвэрлэх Олгойн говийн 29 км хоолой, Хэнтий аймгийн Дархан сумаас Бор өндөрийн уурхай руу 30 км хоолой гэх мэт урсцын хэсгийг шилжүүлэн ашиглах төслүүд хэрэгжиж байгаа билээ.



Манай орон нь 3 ай савын эхэнд орших бөгөөд хур тунадасны усаар бүрэлдэн бий болсон усны нөөцийн 60 гаруй хувь нь ОХУ, БНХАУ руу урсан гардаг. Иймд томоохон хэмжээний ус хуримтлуулан ашиглах асуудлаар хөрш улстай судалгаа шинжилгээний үндэстэй зөвшилцөн ажиллаж байна. Эдийн засгийн болон бусад нөхцөл байдал, томоохон далан, боомт барих эхлэлийн зардал өндөр зэрэг хүчин зүйл тулгарвал цаашид эхний ээлжид голын хөндийн аллювийн хурдас дахь газрын доорх усны нөөцийн тодорхой

хэсгийг алсын зайд шилжүүлэх боломжтой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд усны судалгаанд шинээр нэвтрээд буй изотопын техникийг ашиглан гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарлыг тодорхойлох шаардлагатай байна.

Ашигласан материал

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газраас эрхлэн гаргадаг “Цэнхэр Алт” сэтгүүл, 2021.03.
- Далай Ж. (2011) Ус ба Говь. ISBN 978-99962-0-616-0
- Чинзориг С., Жанчивдорж Л. (2020) Цөмийн технологийг усны менежментэд ашиглах нь. Цөмийн технологи Монгол Улсын хөгжилд.